



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

┌ Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ┐
└ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай ┘

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 7.2.8, 2021 оны 408 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Пүрефинанс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Пүрефинанс ББСБ” ХХК /С.Ган-Очир/-д анхааруулсугай.

3. “Пүрефинанс ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН